



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/555

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ардын хувьсгалын 98 жилийн ойн үндэсний их баяр наадмын халх сурын харвааны төрөлд Монгол улсын Гоц мэргэн цол хүртсэн Дуут сумын харьяат Д.Чулуунбат, Урианхай сурын харвааны төрөлд Хошой мэргэн цол хүртсэн Дуут сумын харьяат Ц.Батзориг нарт хүндэтгэл үзүүлэхэд 600000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрхи зардалд зарцуулах 600000 төгрөг /Зургаан зуун мянган/-ийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтын 5.17-д тусгагдсан "Спортын аварга" хөтөлбөр төслийн зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




Б.ДҮГЭРЖАВ

D/Zax-A/555-Da

02 02747

Аймгийн Засаг даргын 2019 оны
09 дүгээр сарын 06-ны өдрийн
А/555 дугаар захирамжийн хавсралт



ХҮНДЭТГЭЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

дд	Байгууллагын нэр	Мөнгөн дүн
1	Д.Чулуунбат / Гоц мэргэн/	300000
2	Ц.Батзориг / Хошой мэргэн /	300000
	Нийт	600000

-оОо-